

ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ДҮН

Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалар батлагдсан төсвөт байгууллага болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд Аудитын газрын ажилтнуудын хурлаар аудит хийх хуваарь, төлөвлөгөөг хэлэлцэн баталснаар Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн шууд захирагч нар жилийн санхүүгийн тайлангаа баталгаажуулахаар аймгийн Аудитын газарт тайлангаа ирүүлсний дагуу аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын газрын шинэ ажилтнуудад аудит хийх аргазүй, гарын авлагын талаар сургалт зохион байгуулж аудитын тооцооллыг түргэн шуурхай, үнэн зөв гаргах, санхүүгийн тайлангийн үзүүлэлт, уялдаа холбооны алдааг илрүүлэх, санхүүгийн тайлан баталгаажуулахад хэрэглэж хэвшсэн еерсдийн боловсруулсан бичил программыг 13 дахь жилдээ хэрэглэж санхүүгийн тайлан баталгаажуулах аудитыг хийлээ.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу холбогдох хавсралт маягт, загваруудаар ажлын баримт материалыг иж бүрэн бүрдүүлэхэд анхаарч аудитор, шинжээчид ажлын ачаалал, цаг, нөөц боломжийг бүрэн ашиглаж аудитор, шинжээч нарын нөөц боломжийг дайчлан ажилласнаар нийт аудитын дүгнэлт гаргасан байгууллагуудын 96.69 хувийг өөрсдийн хүчээр хийж ажиллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэхь заалтын дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, менежементийн захидлыг Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргад хүргүүлж, баталгаажуулах аудитад орон нутгийн нэгдсэн болон төсөвт байгууллагын 28, тусгай зориулалтын шилжүүлгийн 48, улсын төсвийн 36, орон нутгийн сангийн 1 орон нутгийн өмчит 2 компани нийт 121 байгууллага хамрагдсанаас 78.51 хувь буюу 95-д стандарт болон зөрчилгүй боловч нэмэлт тайлбартай, 19.01 хувь буюу 23-д хязгаарлалттай, 2.48 хувь буюу 3-д дүгнэлт гаргахаас татгалзлаа.

Аудитаар 10248.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад алдааг залруулсан, санхүүгийн тайланд гарсан алдаа өмнөх онд 10226.3 сая төгрөг байсан энэ онд 10248.3 сая төгрөг болж 22.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн тайланд алдаа зөрчлийг гаргахгүй байх, санхүүгийн тайлан тэнцлийг хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэх, удирдлагыг мэдээлэлээр хангах, ажил сайжруулах талаар аудитын дүгнэлт гаргасан болон түүвэрт хамрагдсан 206 байгууллагын дарга эрхлэгч нарт 669 хугацаатай зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн тайланд баталгаажуулахад 2015 онд баримталсан зарчим, түүвэрт хамруулсан, аудитын дүгнэлт гаргасан, аудитын дүн, цаашид хэрхэн ажиллах, улсын хэмжээнд санхүүгийн тайлангийн аудитын байгаа СТАУС программ нэвтрүүлж байгаа талаар боловсрол, эрүүл мэндийн салбарын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарын оролцсон аймгийн 2 удаагийн шуурхай зөвлөлгөөн, сургалт, семинарт оролцон мэдээлэл хийж, мөн санхүүгийн тайлангийн салбар бүрийн дүнг нэгтгэн танилцуулж холбогдох зөвлөмж өгч, цаашид анхаарах асуудлын талаар тодорхой мэдээлэл өгч ажиллаа.

Аудитын дүнгээс орон нутгийн төсөвт байгууллагууд, салбар, байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг хүлээн авч нэгтгэх, нэгтгэхдээ тоо мэдээг тулган баталгаажуулдаг зэргээр тайлан гаргалтын чанар, үр өгөөжид анхаарч ажилласан,

хандив тусламжийн херенгийг бүртгэлд тусгасан байдал емнөх онуудтай харьцуулахад нааштай ахиц өөрчлөлт гарсан ч эд хариуцагч няравууд тайлангаа сар, улирал бүр тогтмол гаргаж хэвшээгүй, ажилдаа хариуцлагагүй ханддаг, тайлан гаргалтын чанар сайжрахгүй байгаа, жилийн эцсийн болон эхний үлдэгдэл зөрүүтэй байдаг, херенгийн тооллого хийгээд үр дүнг тооцдоггүй, урсгалаар явж ирсэн, авлага, өглөгийг тухай бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй, зардлыг зүйл анги, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулдаг, төсвийн төлөвлөлийг тодорхой тооцоо, судалгаанд дээр тулгуурлаж хийдэггүй, шат шатны төрийн сангаас төсвийн херенгийн зарцуулалтанд тавих хяналт сул, эрх нээгдсэн хэмжээгээр зардал гаргадаг, урамшууллыг ажлын бодит үзүүлэлтийг тооцолгүй хавтгайруулан олгодог, туслах аж ахуйн ахуйн ашиг шим, ашиг алдагдлын тооцоог хийлгүй цалин, НДШ, өвс тэжээл, нүүдэл зэрэгт шатахуун болон бусад хэлбэрээр үргүй зардал гаргадаг, санхүүгийн тайланд байгууллагын дарга, эрхлэгч нар ач холбогдол төдийлөн өгдөггүй, санхүүгийн болон тодруулга тайлангийн тоо, тооцоолол, зүйл ангийн үнэн зөв эсэхэд анхаарал тавьдаггүй, төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу хяналт тавьж баталгаажуулдаггүй, нягтлан бодогч нар жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа зардлын бүлэг болон эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан тухай санхүүгийн тайлангийн тодруулгад дэлгэрэнгүй тусгадаггүй нийтлэг алдаа, зөрчил илэрлээ.

АУДИТЫН ГАЗАР